



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/353

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын Журам батлах тухай 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Э.Мөнх-эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	А.Нямцэцэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн орон нутгийн хөгжлийн сан хариуцсан ажилтан
Гишүүд	Б.Баасанжав	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эдийн засаг хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
	Х.Баярбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Ц.Бат-эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон сууц, газрын харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн

2.

Г.Оюун-эрдэнэ	Хүнс, хөдөө аж ахуйн газар Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны дарга
Г.Мөнх-эрдэнэ	Байгаль орчин аялал жуулчлалын газрын Ойн нөхөн сэргээлт, цөлжилт хариуцсан мэргэжилтэн
М.Хишигбаяр	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын, Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга
Б.Дархантөр	“Өндөрхаан хот тохижилт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга
Д.Эрхэмбаяр	Хэнтий ус ХХК Ерөнхий инженер
Т.Төмөрбаатар	Харгуй ТӨХК Ерөнхий инженер
Ч.Адъяа	Иргэний нийгмийн төлөөлөл
Ж.Даваасүрэн	Иргэний төлөөлөл

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Э.Мөнх-эрдэнэ)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ